ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/093/НА-СТА-ТӨҮГ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг<br>Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Б. Долгорсүрэн<br>Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn<br><br>Аудитор: Г. Оюунтөгөлдөр<br>Утас: 261740 Цахим хаяг: oyuntuguldur.g@audit.gov.mn<br><br>“Мэдээлэл Аудит” ХХК-ийн<br>Захирал Д.Товуудорж<br>Утас:70159511, 99049511<br>Цахим хаяг: medeelelaudit@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.17 № 07/1034
танай ______-ны №______-т

ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-ИЙН ЗАХИРАЛ Л.ЭРХБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 699 дүгээр тогтоолоор Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн худалдах цахилгаан энергийн тарифыг тайлант оны 12 дугаар сард нэмэгдүүлэн баталсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрчим хүчний яамны улсын ахлах байцаагчийн 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 11-00-1/14/02 дугаар бүхий Турбогенертор №7 зогсоох тухай актад Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн өндөр даралтын станцын Турбогенератор №7 1977 онд үйлдвэрлэгдсэн, 25 МВт-ын хүчин чадалтай, уурын турбины цилиндр нь металл бүтцийн өөрчлөлтөд орсон байгаа нь Эрчим хүчний үндэсний төвийн лабораторийн

Z:\Yawsan_Bichig\2025\0317 SNAG-41.Docx

1525071166

шинжилгээгээр тогтоогдсон тул 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн түр хугацаагаар зогсоох шийдвэрийг гаргажээ. Турбогенератор №7-г зогсоосноор цахилгаан эрчим хүчний түгээлт 18.0 сая кВт.ц-аар, дулааны эрчим хүчний түгээлт 24.6 мян.гкалаар буурсан байна.

### Бусад асуудал

Оросын Холбооны Улсын ерөнхийлөгч В.В.Путин Монгол улсад хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд байгуулсан “Монгол улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай” Монгол Улсын Засгийн Газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Монгол улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 15-р зүйлийн 15.1-т заасны дагуу Улсын Их Хурлаар соёрхон батлуулах хуулийн дагалдах баримт бичгийн төслийг боловсруулсан байна. Дулааны гуравдугаар цахилгаан ТӨХК-ийн станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг төсөл боловсруулах тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн асуудлыг 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Улсын Их Хурлаар хэлэлцэж, соёрхон баталсан.

### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АУОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

ATA9693 90.6109
9023030583

Z:\Yawsan_Bichig\2025\0317 SNAG-41.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Балансын зүйл | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1.1.01 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 2,457,951,231.92 | 1,146,728,234.22 |
| 1.1.02 | Дансны авлага | 5,865,105,592.45 | 5,258,999,385.55 |
| 1.1.03 | Татвар, НДШ-ийн авлага | 1,857,735,991.89 | 545,637,582.13 |
| 1.1.04 | Бусад авлага | 16,163,952.10 | 119,338,319.06 |
| 1.1.06 | Бараа материал | 15,457,864,719.85 | 19,991,293,060.66 |
| 1.1.07 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 309,909,867.72 | 557,787,040.78 |
| 1.1.08 | Бусад эргэлтийн хөрөнгө | 204,765,158.10 | 204,765,158.10 |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **26,169,496,514.03** | **27,824,548,780.50** |
| 1.2.01 | Үндсэн хөрөнгө | 214,330,934,999.70 | 223,601,845,883.97 |
| 1.2.02 | Биет бус хөрөнгө | 39,583,821,470.44 | 42,829,694,950.53 |
| 1.2.08 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | 0.00 | 949,001,776.48 |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **253,914,756,470.14** | **267,380,542,610.98** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **280,084,252,984.17** | **295,205,091,391.48** |
| 2.1.1.01 | Дансны өглөг | 3,951,361,824.38 | 8,127,430,446.82 |
| 2.1.1.02 | Цалингийн өглөг | 4,275,617.28 | 0.00 |
| 2.1.1.03 | Татварын өр | 268,253,066.32 | 1,235,574,654.83 |
| 2.1.1.05 | Богино хугацаат зээл | 1,778,140,806.52 | 2,264,700,851.73 |
| 2.1.1.06 | Хүүний өглөг | 136,865,649.74 | 180,672,410.33 |
| 2.1.1.08 | Урьдчилж орсон орлого | 43,533,373.00 | 36,468,205.77 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 100,375,332.54 | 342,339,962.66 |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **6,282,805,669.78** | **12,187,186,532.14** |
| 2.1.2.01 | Урт хугацаат зээл | 9,932,725,126.85 | 15,516,325,177.18 |
| 2.1.2.03 | Хойшлогдсон татварын өр | 1,028,571,501.06 | 885,825,635.85 |
| 2.1.2.04 | Бусад урт хугацаат өр төлбөр | 1,613,970,638.49 | 1,259,194,398.71 |
| **2.1.2.06** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **12,575,267,266.40** | **17,661,345,211.74** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **18,858,072,936.18** | **29,848,531,743.88** |
| 2.3.01 | Өмч: - төрийн | 99,362,782,973.56 | 99,362,782,973.56 |
| 2.3.06 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 157,760,921,987.30 | 157,199,785,506.94 |
| 2.3.08 | Эздийн өмчийн бусад хэсэг | 39,454,300,000.00 | 42,708,896,070.00 |
| 2.3.09 | Хуримтлагдсан ашиг | (35,351,824,912.87) | (33,914,904,902.90) |
| 2.3.09.1 | Тайлангийн үеийн ашиг | 0.00 | 875,783,529.61 |
| 2.3.09.2 | Өмнөх үеийн ашиг | (35,351,824,912.87) | (34,790,688,432.51) |
| **2.3.11** | **Эздийн өмчийн дүн** | **261,226,180,047.99** | **265,356,559,647.60** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **280,084,252,984.17** | **295,205,091,391.48** |

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Балансын зүйл | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 01 | Борлуулалтын орлого (цэвэр) | 162,548,726,483.20 | 173,664,317,640.97 |
| 02 | Борлуулалтын өртөг | 148,991,693,705.58 | 168,454,735,849.24 |
| **03** | **Нийт ашиг( алдагдал)** | **13,557,032,777.62** | **5,209,581,791.73** |
| 04 | Түрээсийн орлого | 69,501,638.83 | 79,949,357.32 |
| 05 | Хүүний орлого | 221,969,030.82 | 20,595,102.08 |
| 06 | Ногдол ашгийн орлого | | |
| 07 | Эрхийн шимтгэлийн орлого | | |
| 08 | Бусад орлого | 643,698,019.42 | 13,757,077,173.78 |
| **08.1** | **Орлогын дүн** | **935,168,689.07** | **13,857,621,633.18** |
| 09 | Борлуулалт, маркетингийн зардал | 263,710,899.59 | 369,753,736.97 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 9,514,067,581.19 | 12,554,877,624.61 |
| 11 | Санхүүгийн зардал | 252,049,694.81 | 799,093,448.38 |
| 12 | Бусад зардал | 4,061,457,498.20 | 4,365,081,550.78 |
| **12.1** | **Зардлын дүн** | **14,091,285,673.79** | **18,088,806,360.74** |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | (279,171.63) | (298,490.04) |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | (1,509,012,245.50) | |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | | |
| 17 | Бусад ашиг ( алдагдал) | | |
| 17.1 | Олз, гарзын дүн | (1,509,291,417.13) | (298,490.04) |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал) | **(1,108,375,624.23)** | **978,098,574.13** |
| 19 | Орлогын татварын зардал | 22,196,903.10 | 102,315,044.52 |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | **(1,130,572,527.33)** | **875,783,529.61** |
| 21 | Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал) | | |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал) | **(1,130,572,527.33)** | **875,783,529.61** |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | | |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | | |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | |
| 23.3 | Бусад олз (гарз) | | |
| 24 | Орлогын нийт дүн | | |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | | |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Өмч | Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл | 99,362,782,973.56 | 157,971,926,506.86 | 38,922,250,000.00 | (34,432,256,905.10) | 261,824,702,575.32 |
| 2 | НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө,алдааны залруулга | | | | 211,004,519.56 | 211,004,519.56 |
| 3 | Залруулсан үлдэгдэл | 99,362,782,973.56 | 157,971,926,506.86 | 38,922,250,000.00 | (34,221,252,385.54) | 262,035,707,094.88 |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | (1,130,572,527.33) | (1,130,572,527.33) |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | | | 532,050,000.00 | | 532,050,000.00 |
| 7 | Зарласан ногдол ашиг | | | | | |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | (211,004,519.56) | | | (211,004,519.56) |
| 9 | 2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл | 99,362,782,973.56 | 157,760,921,987.30 | 39,454,300,000.00 | (35,351,824,912.87) | 261,226,180,047.99 |
| 10 | НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө,алдааны залруулга | | | | 561,136,480.36 | 561,136,480.36 |
| 11 | Залруулсан үлдэгдэл | 99,362,782,973.56 | 157,760,921,987.30 | 39,454,300,000.00 | (34,790,688,432.51) | 261,787,316,528.35 |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | 875,783,529.61 | 875,783,529.61 |
| 13 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | | | 3,254,596,070.00 | | 3,254,596,070.00 |
| 15 | Зарласан ногдол ашиг | | | | | |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | (561,136,480.36) | | | (561,136,480.36) |
| **17** | **2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл** | **99,362,782,973.56** | **157,199,785,506.94** | **42,708,896,070.00** | **(33,914,904,902.90)** | **265,356,559,647.60** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Балансын зүйл | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| **1.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **173,234,087,469.29** | **184,970,512,464.27** |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 172,671,404,526.74 | 169,931,246,935.00 |
| 1.1.2 | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | | |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 204,362,344.50 | 235,215,726.00 |
| 1.1.4 | Буцаан авсан албан татвар | | |
| 1.1.5 | Татаас, санхүүжилтийн орлого | | 14,316,861,000.00 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 358,320,598.05 | 487,188,803.27 |
| **1.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **162,683,656,104.15** | **171,310,337,002.71** |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 33,263,902,681.89 | 41,061,524,023.66 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 10,266,100,000.00 | 12,526,025,056.00 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 87,657,855,879.36 | 84,867,586,353.34 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 1,870,360,387.15 | 2,643,787,185.63 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн | 16,674,732,140.56 | 15,148,862,439.83 |
| 1.2.6 | Хүүний төлбөрт төлсөн | 51,435,944.77 | 9,204,430.68 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 9,598,631,710.24 | 11,623,316,965.85 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 59,560,990.00 | 5,700,000.00 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 3,241,076,370.18 | 3,424,330,547.72 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **10,550,431,365.14** | **13,660,175,461.56** |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| **2.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **221,966,724.48** | **20,595,102.08** |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | |
| 2.1.2 | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | | |
| 2.1.3 | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | | |
| 2.1.4 | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | | |
| 2.1.5 | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | | |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | 221,966,724.48 | 20,595,102.08 |
| 2.1.7 | Хүлээн авсан ногдол ашиг | | |
| **2.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **11,743,382,914.79** | **14,024,367,939.59** |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 11,742,172,914.79 | 14,024,367,939.59 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 1,210,000.00 | |
| 2.2.3 | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | | |
| 2.2.4 | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| 2.2.5 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | | |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(11,521,416,190.31)** | **(14,003,772,837.51)** |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| **3.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | | |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| 3.1.2 | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| 3.1.3 | Төрөл бүрийн хандив | | |
| **3.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **213,415,199.32** | **967,625,621.75** |
| 3.2.1 | Зээл,өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 213,415,199.32 | 967,625,621.75 |
| 3.2.2 | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | | |
| 3.2.3 | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | | |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | | |
| 3.2.5 | Бусад | | |
| **3.3** | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(213,415,199.32)** | **(967,625,621.75)** |
| **4** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(1,184,400,024.49)** | **(1,311,222,997.70)** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **3,642,351,256.41** | **2,457,951,231.92** |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **2,457,951,231.92** | **1,146,728,234.22** |

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| д/д | Эдийн засгийн үндсэн үзүүлэлт | | Хэмжих нэгж | Өмнөх оны гүйцэтгэл | 2024 он | | Өөрчлөлт /өссөн +, буурсан -/ | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| 1 | Боловсруул сан: | Цахилгаан эрчим хүч | мян.квтц | 1,132,330.8 | 1,112,591.9 | 1,114,965.7 | 2,373.8 | 0.0 |
| | ДХЦЭХ | хувиар | хувь | 16.6 | 17.1 | 16.9 | (0.2) | (0.0) |
| | | биетээр | мян.кВтц | 187,999.0 | 190,586.0 | 188,592.8 | (1,993.2) | (0.0) |
| | Эрчим хүчний түгээлт | ЦЭХ | мян.квтц | 944,331.8 | 922,005.9 | 926,372.9 | 4,367.0 | 0.0 |
| | | ДЭХ | Гкал | 2,527,955.0 | 2,573,936.0 | 2,579,469.0 | 5,533.0 | 0.0 |
| 2 | **Нийт орлого** | | **мян.төг** | **163,565,826.8** | **185,878,105.7** | **187,521,939.3** | **1,643,833.5** | 0.0 |
| | Үүнээс: | Цэвэр борлуулалт | мян.төг | 162,548,726.5 | 172,935,577.6 | 173,664,317.6 | 728,740.1 | 0.0 |
| | | Үйл ажиллагааны бус орлого | мян.төг | 1,017,100.3 | 927,200.0 | 842,293.5 | (84,906.6) | (0.1) |
| | | Татаас /санхүүжилт/ | мян.төг | | 12,015,328.2 | 13,015,328.2 | 1,000,000.0 | 0.1 |
| 3 | **Нийт зардал** | | **мян.төг** | **164,674,202.5** | **190,795,743.5** | **186,543,840.7** | **(4,251,902.8)** | (0.0) |
| | Үүнээс: | Үйл ажиллагааны зардал | мян.төг | 162,351,009.0 | 190,025,382.2 | 185,664,409.1 | (4,360,973.1) | (0.0) |
| | | Үйл ажиллагааны бус зардал | мян.төг | 2,323,193.5 | 770,361.3 | 879,431.6 | 109,070.3 | 0.1 |
| 4 | **Татварын өмнөх ашиг/алдагдал -/** | | **мян.төг** | **(1,108,375.6)** | **(4,917,637.7)** | **978,098.6** | **5,895,736.3** | (1.2) |
| 5 | **Цэвэр ашиг / алдагдал -/** | | **мян.төг** | **(1,130,572.5)** | **(4,917,637.7)** | **875,783.5** | **5,793,421.3** | (1.2) |
| 6 | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | | мян.төг | 1.0 | 1.1 | 1.1 | (0.0) | (0.0) |
| 7 | **Нийт авлага** | | **мян.төг** | **7,739,005.5** | **11,409,739.1** | **6,872,977.1** | **(4,536,762.0)** | (0.4) |
| | Үүнээс: | Эрчим хүчний | мян.төг | 5,865,105.6 | 9,949,739.1 | 5,258,999.4 | (4,690,739.7) | (0.5) |
| | | Бусад | мян.төг | 1,873,899.9 | 1,460,000.0 | 664,975.9 | (795,024.1) | (0.5) |
| 8 | **Нийт өглөг** | | **мян.төг** | **18,858,072.9** | **31,658,891.7** | **29,848,531.7** | **(1,810,359.9)** | (0.1) |
| | Богино хугацаат өр төлбөр | | мян.төг | 6,282,805.7 | 13,143,490.8 | 12,187,186.5 | (956,304.2) | (0.1) |
| | Урт хугацаат өр төлбөр | | мян.төг | 12,575,267.3 | 18,515,400.9 | 17,661,345.2 | (854,055.7) | (0.0) |
| 9 | Нийт ажиллагсдын тоо | | хүн | 977.0 | 1,001.0 | 976.0 | (25.0) | (0.0) |
| 10 | **Нийт цалингийн сан** | | **мян.төг** | **34,362,817.9** | **49,988,842.1** | **48,279,361.8** | **(1,709,480.3)** | (0.0) |
| 11 | Нэг ажиллагчийн дундаж цалин /ЖҮД-тэй/ | | төг | 2,930,980.7 | 4,161,575.3 | 4,124,326.1 | (37,249.1) | (0.0) |
| 12 | Жишмэл түлшний хувийн зарцуулалт | цахилгаан | гр/кВтц | 312.9 | 320.6 | 320.3 | (0.3) | (0.0) |
| | | дулаан | кг/Гкал | 175.8 | 176.1 | 176.0 | (0.1) | (0.0) |
| 13 | **Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт** | | **мян.төг** | **18,200,525.1** | **31,858,878.4** | **22,069,834.7** | **(9,789,043.7)** | (0.3) |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1. Аудитаар нийт 1,128.3 сая төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Д.д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн 176.0 сая төгрөгийг түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгөөр тайлагнаж, мөнгөн гүйлгээний тайланд буруу ангилж тайлагнасан | 1 | 176,000.0 | | | 1 | 176,000.0 | 1 | 176,000.0 | | | | |
| 2 | Үндсэн хөрөнгийн хувь тэнцүүлэн хасагдуулах 949.0 сая төгрөгийн НӨАТ-ын авлагыг эргэлтийн хөрөнгийн ангилалд буруу тайлагнасан | 1 | 949,001.7 | | | 1 | 949,001.7 | 1 | 949,001.7 | | | | |
| 3 | 2024-06-28-ны өдөр буюу УИХ-ын ээлжит сонгуультай, бүх нийтийн амралтын өдөр ажилчдын хоолны мөнгийг олгосон | 1 | 3,393.0 | 1 | 3,393.0 | | | 1 | 3,393.0 | | | | |
| | **Дүн** | **3** | **1,128,394.7** | 1 | **3,393.0** | **2** | **1,125,001.7** | | **1,128,394.7** | | | | |

3.2. Аудитаар нийт 242.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 6.0 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 230.7 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 5.9 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | 2024-06-28-ны өдөр буюу УИХ-ын ээлжит сонгуультай, бүх нийтийн амралтын өдөр 3.3 сая төгрөгийн ажилчдын хоолны мөнгө олгосон. | 1 | 3,393.0 | 1 | 3,393.0 | | | | | | | | |
| 2 | Төлөвлөгөөнд тусгаагүй 2.6 сая төгрөгийн шатахууныг ТУЗ-ын гишүүдэд олгосон. | 1 | 2,636.6 | 1 | 2,636.6 | | | | | | | | |
| 3 | Төлөвлөгөөнд тусгаагүй 28.5 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал ТУЗ-ын гишүүдэд олгосон. | 1 | 28,500.0 | | | 1 | 28,500.0 | | | | | | |
| 4 | Турбогенератор №4 -ийн их засварын ажил гүйцэтгэх гэрээт ажилд тусгагдсан солих ёстой материал нь техникийн шаардлага хангасан шалтгаанаар солигдоогүй үлдсэн 94.0 сая төгрөгийн бараа материалыг гүйцэтгэгч компаниас худалдан авсан. | 1 | 94,050.0 | | | 1 | 94,050.0 | | | | | | |
| 5 | 2024 оны 5 дугаар сарын 02-ны өдөр №3ГАБ-ЧГ-24/61 дугаар "Туулах чадвар сайтай автомашинаар үйлчилгээ үзүүлэх, төлбөр тооцоо барагдуулах гэрээ"-г байгуулж, өөрийн үйл ажиллагаанд | 1 | 28,400.0 | | | 1 | 28,400.0 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хамааралгүй, худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй үйлчилгээнд хөрөнгө зарцуулсан. | | | | | | | | | | | | |
| 6 | Майнримек ХХК, Блейк стар альфа ХХК, Огмент ХХК, Визлис визард ХХК-уудтай байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контентын үйлчилгээ авах гэрээг байгуулж, өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй, худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй үйлчилгээнд хөрөнгө зарцуулсан. | 1 | 79,840.0 | | | 1 | 79,840.0 | | | | | | |
| 7 | Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024.07.08-ны өдрийн № 7 дугаар тогтоолоор төрийн өмчийн төлөөлөл болох ТӨБЗГ-ын ерөнхий нягтлан бодогч Д.Отгонтуяаг ТУЗ-ийн хараат бус гишүүн /Аудитын хорооны дарга/-аар томилсон. | 1 | | | | 1 | | | | | | | |
| 8 | 2024 оны 1, 3, 8 сарын кассын журамд зааснаас илүү үлдэгдлийг харилцах дансанд тушаагаагүй байгаа. | 1 | 5,926.7 | | | | | 1 | 5,926.7 | | | | |
| | **Дүн** | **8** | **242,746.3** | **2** | **6,029.6** | **5** | **230,790.0** | **1** | **5,926.7** | | | | |

3.2. АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил илэрснээс, 1 албан шаардлага өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| *Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил* | | | | | | | | |
| ДЦС3/20240102076 дугаар Гэрэлтүүлгийн материалын тендерийн төлөвлөгөөнд заасан үнэ шалгарсан байгууллагын илгээсэн үнийн санал Бууруулагч трансформатор 380/36В, Бууруулагч трансформатор 220/12В,ЯТП-0,25, Трансформатор ОСМ-1-0,4УЗ 0,4кВа гэсэн 3 төрлийн бараанд хэт өндөр үнийн санал илгээсэн байна. Оролцогч арифметик алдаа гаргасныг захиалагч залруулах тодруулга аваагүй. | 1 | | | | 1 | | | |
| **Нийт дүн** | **1** | | | | **1** | | | |